



МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛ,  
СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН  
САЙДЫН ТУШААЛ

2018 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/492

Улаанбаатар хот

Сургалтын хөтөлбөр батлах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Бага, дунд боловсролын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн бага боловсролын Бэлтгэл хөтөлбөрийг нэгдүгээр, Монгол хэлний сургалтын хөтөлбөрийг хоёрдугаар, Математикийн сургалтын хөтөлбөрийг гуравдугаар, Яриа бичгийн сургалтын хөтөлбөрийг дөрөвдүгээр, Биет зүйлийн сургалтын хөтөлбөрийг тавдугаар, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийг зургаадугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.

2. Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгал сургалтын хөтөлбөрийг 2018-2019 оны хичээлийн жилээс эхлэн сургуулийн хэмжээнд хэрэгжүүлж ажиллахыг сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн захирал /Б.Батсайхан/-д даалгасугай.

3. Сонсголын бэрхшээлтэй 29 дүгээр тусгай сургуулийн Бэлтгэл, Монгол хэл, Математик, Яриа бичиг, Биет зүйл, Айзамт хөдөлгөөнт дасгалын сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт тавьж, мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын бодлогын газрын дарга /Т.Ням-Очир/, Боловсролын хүрээлэн /П.Лхагвасүрэн/-д тус тус үүрэг болгосугай.

САЙД



ЦӨГЗОЛМАА

Боловсрол, соёл, шинжлэх ухааны спортын  
сайдын 2018.08.08-саяын 4/102 өмчийн  
тоот тушаалын 3-хавсралт



## СОНСГОЛЫН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮҮХДИЙН 29 ДҮГЭЭР ТУСГАЙ СУРГУУЛИЙН БАГА БОЛОВСРОЛЫНЦИ БИЕТ ЗҮЙЛ ХӨТӨЛБӨР

### НЭГ. ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Оросын Холбооны Улсын Сурган Хүмүүжүүлэх Ухааны Академийн "Соог заслын институт"-эд сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан сургуулийн "Предметно-практическое обучение-Биет практик сургалт"-ыг ерөнхий боловсролын хичээлтэй холбон судалж, С.А.Зыкова, Т.С.Зыкова, Т.В.Нестерович нарын эрдэмтэн судлаачид Биет зүйл сургалтын зорилго, зорилт түүний агуулга, арга зүйгээр "...нэг сэдэвт зохиол, гарын авлага"<sup>1</sup> олныг туурвижээ.

"Предметно-практическое обучение-Биет практик сургалт"-ын зорилго, зорилтыг сонсголын бэрхшээлтэй хүүхдэд "Амьдралын тухай ойлголтыг төлөвшүүлэх замаар шинжлэх ухааны үндсийг эзэмшихэд нь бэлтгэх"<sup>2</sup>, "Гар хөдөлмөртэй холбоотой мэдлэг, чадварыг төлөвшүүлэх"<sup>3</sup>, "...хүүхдийн танин мэдэх үйл явц болох хүртэхүй, анхаарал, ой санамж, дүрслэн бодохуй ба сэтгэхүйг хөгжүүлэх"<sup>4</sup> гэж тодорхойлжээ.

Хүний бие эрхтэн, гэр бүл, хоол хүнс, хувцас, харилцан яриа, хичээлийн хэрэглэл, цаг хугацаа, байгаль, байгалийн үзэгдэл, амьтан, тээврийн хэрэгсэл, асуух үг, төлөөний үг, үйл үг, урт, богино, том, бага, баруун, зүүн, дээр, доор, удаан, түргэн, олон, цөөн гэх мэт үг хэллэг нь хүний амьдралын тухай ойлголтын төрөл юм.

Сонсголын бэрхшээлтэй хүүхдийн 29 дүгээр тусгай сургуулийн "Биет зүйл" хөтөлбөрийн агуулга нь "Биет, танил зүйл зурах, чимэглэх", "Биет, танил зүйл бүтээх, чимэглэх", "Дүрслэх урлагийн яриа" гэсэн 3 бүлэгтэй.

Биет, танил зүйл зурах, бүтээх явцад сурагчид юмс, үзэгдлийг ажиглах, харьцуулах, нэгтгэн дүгнэх замаар түүний шинж чанар, онцлогийн тухай энгийн мэдлэг, чадвар эзэмшинэ. Биет зүйл зурах, бүтээх, чимэглэх нь сурагчдын харааны ой, орон зайн төсөөллийг хөгжүүлж, гарын хөдөлгөөнийг зүгшрүүлэх, нүдний ба гарын баримжааллыг нэгтгэх онцгой ач холбогдолтой юм.

Сонсгол, хэл ярианы бэрхшээлтэй хүүхэд юмсыг дуурайлган өөрийн бодол төсөөллөөр зурах, бүтээх явцдаа, юмсыг таних, хэлбэр, өнгийг нэрлэх, их бага, урт богино, бүрдэл хэсгийг тоолж сурснаар тэдэнд орон зайн чадамж /юмсын хэлбэр, дүрс, хэмжээ, өнгө зохицол/ түүнчлэн гоо зүйн мэдрэмж төлөвших эхлэл бий болдог.

<sup>1</sup> Т.С.Зыкова и др. Уроки предметно-практического обучения в школе глухих. Пособие для учителей. М. Просвещение 1980. Стр 3

<sup>2</sup> Т.С.Зыкова и др. Уроки предметно-практического обучения в школе глухих. Пособие для учителей. М. Просвещение 1980. Стр 6

<sup>3</sup> Т.С.Зыкова и др. Уроки предметно-практического обучения в школе глухих. Пособие для учителей. М. Просвещение 1980. Стр 11

<sup>4</sup> Т.С.Зыкова и др. Уроки предметно-практического обучения в школе глухих. Пособие для учителей. М. Просвещение 1980. Стр 8